

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 4 сарын 24

дугаар 01

Шарын гол сум

Компанийн жилийн үйл ажиллагааны болон
Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
удирдах зөвлөлийн дүгнэлтийн тухай

“Шарын гол” хувьцаат компанийн 2025 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд,

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДСАЙХАН

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2026 оны 4 сарын 24

дугаар 02

Шарын гол сум

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны цалин урамшуулал, зардлын төсөв
батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны цалин урамшуулал, зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Б.МЭНДСАЙХАН

2026 оны 4-р сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын 02 дугаартай тогтоолын Хавсралт



Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны төсөв

д/д	Зардлын төрөл	НИЙТ ЗАРДАЛ төгрөгөөр
1	Цалин	167,400,000
2	НДШ ЭМД	24,273,000
3	АТБӨЯХ-ийн албан татвар	531,254
4	ҮХЭлэгдэл	63,652,628
	Нийт	255,856,882

---000---